

Бичил уурхайгаар ашигт малтмал  
олборлох тухай гэрээ

01/09/2019  
А. Дугаар  
Хуучир. 98505699

2019 оны 01 дугаар сарын 09-ны өдөр

Дуурлиг

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 2.4, 3.1.3, 6.1.3-т заалтын дагуу н талаас Хэнтий Аймаг/хот/-ын Баян-Адарга сум/Дүүрэг/-ийн Засаг дарга Оросоо овогтс Лхагвадорж /цаашид "Засаг дарга" гэх/ нөгөө талаас бичил уурхайн "Хайрхан баял жонш" нэртэй нөхөрлөл /цаашид "Нөхөрлөл" гэх/-ийг төлөөлж нөхөрлөлийн ахлагч Аюу овогтой Адъяажав бид нар /цаашид хамтад нь Талууд гэх/ дараах нөхцлөөр харилца тохиролцож 2019 оны 01 дугаар сарын 09-ны өдөр энэхүү гэрээ /цаашид "Гэрээ" гэх/-и Баян-Адарга /сум/дүүрэг/-д байгуулав.

### Нэг Ерөнхий зүйл

- 1.1 Бичил уурхай эрхлэгч этгээд нь Баян-Адарга сум/дүүрэг/-ийн Хөлийн холбоо нэрт газарт орших 0.8 гектар талбайд журмын 6.1.3-т заасны дагуу 1 жилийн хугацаага жонш /ашигт малтмалыг төрөл/ олборлох үйл ажиллагаа эрхэлнэ.
- 1.2 Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар сум/дүүрэг/-ийн Засаг дарг бичил уурхай эрхлэгч этгээдийн хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулн

### 1.3 Хоёр. Сум, дүүргийн Засаг даргын эрх, үүрэг

- 2.1 Сум дүүргийн Засаг дарга нь бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын дугаар зүйлд зааснаас гадна дараах үүрэг хүлээнэ. Үүнд
  - 2.1.1 "Бичил уурхай эрхлэгч этгээдэд ногдох талбайн хэмжээг тогтоож байршлын зурги гэрээнд хавсаргах
  - 2.1.2 хог хаягдлын цэгийн байршлыг тогтоож өгөх
  - 2.1.3 Бичил уурхай эрхлэгч этгээдийн олборлосон ашигт малтмалыг ангилах, ялгах ц талбайн байршлыг тогтоож өгөх
  - 2.1.4 Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу нөхөн сэргээлтийн зардл тооцож, бичил уурхай эрхлэгч этгээдтэй тохиролцсоны үндсэн дээр зохих хөрөнги төвлөрүүлэх
  - 2.1.5 Бичил уурхайн ажилтнуудад /цаашид ажилтан гэх/ зориулсан хөдөлмөрийн аюулг ажиллагааны сургалтыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар зохион байгуулах
  - 2.1.6 Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг бичил уурхай эрхлэгч этгээдэ шаардах
  - 2.1.7 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хяна тавих
  - 2.1.8 Хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа үйл ажиллагааг зогсоох

### Гурав. Бичил уурхай эрхлэгч этгээдийн эрх, үүрэг

- 3.1 Бичил уурхай эрхлэгч этгээд дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.
  - 3.1.1 Бичил уурхай эрхлэгч этгээдэд олгосон талбайд ашигт малтмал олборлох үл ажиллагааг явуулах
  - 3.1.2 Нөхөрлөлийн гишүүдийг тогтоосон бүсэд суурьшуулах
  - 3.1.3 суурьшлын талбайг тохижуулж, ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлын цэги байгуулах

- 3.1.4 Гэрээгээр олгосон талбайд нөхөрлөл, хоршоо, бүртгэгдээгүй нөхөрлөлийн гишүү бус этгээдийг ажиллуулахгүй байх
- 3.1.5 байгаль орчныг хамгаалж гол, горхи, булаг шанд, уст цэгийг бохирдуулахгүй байх
- 3.1.6 бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг дагаж мөрдөх, болзошгүй ослос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
- 3.1.7 хууль тогтоомж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон нөхө сэргээлтийн чиглэлээр ажилтнуудад сургалт, сурталчилгаанд бичил уурхайчды идэвхитэй оролцуулах
- 3.1.8 Ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах үйл ажиллагааг тогтоосон талбай, гүйцэтгэх
- 3.1.9 үйл ажиллагаандаа химийн хорт болон аюултай бодис хэрэглэхгүй байх, тусга зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгсэл ашиглахгүй байх
- 3.1.10 Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл, мөн хуулийн 36.4-т заасан хоршооны зохион байгуулалтад орсон бичил уурхай эрхлэгч этгээд нь ашигт малтма, олборлох үйл ажиллагаанд 3500см<sup>3</sup> хүртэлх багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүү бүхий 2-оос илүүгүй механизмыг ашиглах
- 3.1.11 бичил уурхайн нөхөр сэргээлтийн аргачлалын дагуу эрх бүхий этгээдийн тогтоосо байгаль орчны нөхөн сэргээлтийн зардалд шаардагдах .....500000..... төгрөгий /100181155408/ тоот дансанд төвлөрүүлэх
- 3.1.12 Нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлсэн хөрөнгийг олборлолт явуулса талбайд нөхөн сэргээлтэд зарцуулах
- 3.1.13 бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу олборлолт явуулса талбайдаа нөхөн сэргээлт хийж сум, дүүргийн Засаг даргын томилсон комисст хүлээлгэ өгөх
- 3.1.14 олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу худалдан авах эрх бүхи хуулийн этгээдэд худалдах
- 3.1.15 ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, холбогдох хууль тогтоомжийн дагу орлогын албан татвар төлөх
- 3.1.16 Бичил уурхай эрхлэгч этгээд нөхөн сэргээлт хийж талбайг хүлээлгэн өгсөний дара ашигт малтмал олборлох өргөдөл дахин гаргах
- 3.1.17 Бичил уурхай эрхлэгч этгээд нийгмийн хариуцлагын хүрээнд гэрээ байгуул; хамтран ажиллах
- 3.1.18 Гадаадын иргэн харъяатыг хууль бусаар ажиллуулахгүй байх, ажиллуулса тохиолдолд холбогдох хууль, журмын дагуу хариуцлага хүлээх

#### **Дөрөв. Харилцан хүлээх үүрэг**

- 4.1 Гэрээнд оролцогч талууд харилцан хүндэтгэх зарчим дээр тулгуурлан хамтар ажиллана
- 4.2 Гэрээний дагуу бичил уурхайгаар ашигт малтмал олборлох байгаль орчин, буса этгээдэд хохирол учруулсан тохиолдолд бичил уурхай эрхлэгч этгээд уг хохирль барагдуулах үүрэгтэй. Сум дүүргийн Засаг дарга байгаль орчинд учруулсан хохирль арилгуулахыг бичил уурхай эрхлэгч этгээдээс шаардана
- 4.3 Журам, гэрээний үүргээ биелүүлээгүй буюу зөрчсөн тохиолдолд бичил уурха эрхлэгчтэй байгуулсан гэрээг цуцалж, хууль тогтоомжид заагдсан хариуцлага хүлээлгэнэ

4.4 Талууд энэхүү гэрээний биелэлтийг жил бүр хамтран дүгнэж аймаг /нийслэл/-ий Засаг даргад дараа оны 1 дүгээр сард багтааж тайлагнана

#### Тав. Маргаан шийдвэрлэх

5.1 Талууд гэрээтэй холбоотой үүссэн аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцс замаар шийдвэрлэнэ.

5.2 Талууд харилцан тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хуул тогтоомжийн дагуу маргааныг шийдвэрлэнэ.

#### Зургаа. Гэрээний хүчин төгөлдөр болох хугацаа

6.1 Энэхүү гэрээ нь 2019 оны 01 сарын 09 өдрөөс 2020 оны 01 сарын 09 өдө хүртэл хугацаанд үйлчилнэ.

6.2 Бичил уурхайгаар ашигт малтмал олборлосон талбайд нөхөн сэргээлт хийж оро нутагт хүлээлгэж өгснөөр энэхүү гэрээний үүрэг дуусгавар болно.

6.3 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.

#### Долоо. Гэрээнд оруулах нэмэлт өөрчлөлт

7.1 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцсоны үндсэ дээр шийдвэрлэнэ.


7.2 Нийгмийн хариуцлагын хүрээнд тухайн жилийн нийгэм эдийн засгийн үндсэн чиглэл, тусгагдсан хөрөнгө оруулалт болон бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлж хамтраа ажиллах

7.3 Энэхүү гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь түүний нэгэн адил хүчинтэй байх бөгөө, гэрээний салшгүй хэсэг болно.

Гэрээ байгуулсан:

Хэнтий аймгийн Баян-Адарга  
сумын Засаг дарга

"Хайрхан баялаг жонш" нөхөрлөлийн ахлагч

  
/О.Лхагвадорж/  
А.Адъяажав/  
БАЯН-АДАРГА СУМ  
ЗАСАГ ДАРГА